



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн
Засаг даргын 2024-2028 оны үйл
ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит II хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

2.1.Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт батлан хэрэгжүүлэх;

2.2.Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн дүүргийн төсөвт тусган хэрэгжүүлэх;

2.3.Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр тайлагнах;

3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.


ДАРГА

Т.УЛАМБАЯР

D/2024-togtooli

1501001.0

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 12 дугаар сарын 06-ны
өдрийн 07 дугаар тогтоолын хавсралт



Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын
2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр

НЭГ.БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

УЛААНБААТАР “20 МИНУТЫН ХОТ”:

1.1.Улаанбаатар “20 минутын хот” үзэл баримтлалын дагуу иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.

1.1.1.“Сэлбэ”, “Дэнжийн мянга” дэд төвүүдийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах замаар “Чингэлтэй хот”-ыг хөгжүүлнэ.

1.1.2.Дэд төвд хүн амын хэрэгцээ шаардлагад тулгуурлан сургууль, цэцэрлэг, хүнсний зах, худалдааны болон ахуйн үйлчилгээний төвүүдийг байгуулна.

1.1.3.“Дэнжийн мянга дэд төв”-ийг түшиглэн дүүргийн Төр захиргааны төв байр, Соёлын ордон, Албан хаагчдын орон сууц бүхий цогцолбор төвийг барьж байгуулна.

1.1.4.Дүүргийн 7, 8, 9 дүгээр хороодын айл өрхийн газрыг байраар солих журмаар газар чөлөөлөлт хийнэ.

1.2.Дахин төлөвлөлтийг эрчимжүүлж, төвлөрлийг сааруулах замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулна.

1.2.1.Дүүргийн 7, 8, 9 дүгээр хороодын нутаг дэвсгэрт төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлнэ.

1.2.2.Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцны оршин суугчдын саналыг үндэслэн төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлнэ.

1.2.3.Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, дээвэр, фасад, инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчилж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

1.2.4.Цагдаа, түргэн тусламж, гал унтраах аврах ажиллагаа шуурхай хүрэх, нэвтрэх нөхцөл, иргэдийн зорчих боломжийг бүрдүүлж, гэр хороолол,

зуслангийн бүсийн орц, гарц, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийг арилгана.

1.3.Эрчим хүчний эх үүсвэр, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар тасралтгүй найдвартай байдлыг хангаж, иргэдийн амьдрах таатай орчныг сайжруулна.

1.3.1.“Дэнжийн мянга дэд төв”-ийн 50МВт-ын хийн болон “Дамбадаржаа дэд төв”-ийн 63МВт-ын дулааны эх үүсвэрт тухайн нутаг дэвсгэрт байрлах аж ахуйн нэгж байгууллага, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төр захиргааны байр, албан хаагчдын орон сууцны хэрэглэгчдийн холбогдох нөхцөлийг бүрдүүлнэ.

1.3.2.Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг тархмал хэлбэрээр гэр хороололд суурилуулах төслийг төр-хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн хэрэгжүүлнэ.

1.3.3.Дүүргийн нутаг дэвсгэр дэх Таван буудал, Хайлааст, Чингэлтэй, Дэнжийн мянга орчмын газар чөлөөлөлтийг үргэлжлүүлж, орон сууцжуулах бодлого баримтлан агаар, орчны бохирдлыг бууруулна.

1.3.4.Гэр хорооллын алслагдсан хороодод сэргээгдэх эрчим хүчний болон хэсэгчилсэн инженерийн дэд бүтцийг бий болгож, агаар, хөрсний бохирдлыг бууруулна.

1.3.5.Голуудын эргийн хамгаалалтын далан, үерийн эрсдэл бүхий байршил дахь айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх, чөлөөлөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, далан суваг, хөв цөөрөм, хөрсний усны шугам сүлжээг барьж, үерийн усны эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлнэ.

1.3.6.Хүчдэлийн уналттай айл өрхийг найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах, хүчдэлийн уналтыг бууруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

АВТО ЗАМ:

1.4.Авто замын сүлжээ төлөвлөлтийг сайжруулан, авто замын хүртээмжийг нэмэгдүүлж, түгжрэлийг бууруулна.

1.4.1.Авто зам, замын гүүрэн байгууламж, үндсэн сүлжээ, тойрог болон туслах зам, замын ус зайлуулах шугам сүлжээний шинэчлэлтийн ажил, зам засварлах ажлуудыг хэрэгжүүлнэ.

1.4.2.Сургууль, цэцэрлэг, эмнэлэг орчимд авто замын аюулгүй байдлыг хангасан цогц төсөл, арга хэмжээг санаачлан хэрэгжүүлнэ.

1.4.3.Авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлж, газар дээрх болон доорх зогсоолыг төр-хувийн хэвшлийн хамтын санхүүжилт, менежментийн зарчмаар барьж байгуулах ажлыг эрчимжүүлнэ.

НИЙТИЙН ТЭЭВЭР:

1.5.Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлнэ.

1.5.1.Нийтийн тээврээр зорчигчдын ая тухтай байдлыг хангаж, нийтийн тээврийн дундын болон эцсийн зогсоолуудыг дулаан саравч бүхий тохилог орчинтой болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.5.2.Гэр хорооллын дундах авто замыг өргөтгөн шинэчилж, нийтийн тээврээр зорчих боломжийг бүрдүүлэн, иргэдэд үйлчлэх чиглэлийг нэмэгдүүлнэ.

ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

БОЛОВСРОЛ:

2.1.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдлагын менежментийг сайжруулж, олон улсын сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлэн сургалтын чанар, гүйцэтгэлийн зөрүүтэй байдлыг арилгана.

2.1.1.Боловсролын байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, боловсролын ялгааг арилгах зорилгоор **"Чингэлтэйн боловсрол-2028"** арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.

2.1.2.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад Олон улсын I'm brick, Steam, Montessori зэрэг хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.1.3.Боловсролын салбарт олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, сайн туршлагаас суралцан түгээх чиглэлээр багш, сурагч солилцооны хөтөлбөрийг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

2.1.4.Багш нарын мэдлэг ур чадварыг сайжруулахад чиглэсэн олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлж, дотоод гадаадын урт болон богино хугацааны сургалтад хамрагдахыг дэмжинэ.

2.2.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт шаардлагатай засвар үйлчилгээг хийж, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэн сургалтын таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.1.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг зөөврийн компьютероор бүрэн хангаж, цахим хичээл, алсын зайн сургалт явуулах нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ.

2.2.2.Ерөнхий боловсролын сургуулиудад орчин үеийн стандартын шаардлага хангасан "Усан бассейн бүхий спорт сургалтын цогцолбор"-ыг үе шаттайгаар байгуулна.

2.2.3.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд шаардлагатай засвар үйлчилгээ, тохижилтыг хийж, сургалтын таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.4.Сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, судлагдахууны жишиг төрөлжсөн кабинет байгуулах ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.

2.3.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, төрийн байгууллага, эцэг эх, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлнэ.

2.3.1.Хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, хоол үйлдвэрлэлийг бие даан гүйцэтгэх сургуулийн тоог нэмэгдүүлнэ.

2.3.2.Хоол үйлдвэрлэлд төрийн байгууллага, эцэг эх, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлнэ.

2.3.3.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүн нэмэлтээр олгож, хүүхдийн ясны бүтэц, өсөлт хөгжлийг дэмжих "Сүү" хөтөлбөрийг хамтын санхүүжилтээр хэрэгжүүлнэ.

ЭРҮҮЛ МЭНД:

2.4.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулна.

2.4.1.Дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.

2.4.2."Эрт илрүүлэг оношилгооны төв"-ийн барилгыг ашиглалтад оруулж, эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлгийн ажлыг тасралтгүй зохион байгуулна.

2.4.3."**Эрүүл, спортлог Чингэлтэйчүүд-2028**" арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.

2.4.4.Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, нөхөн үржихүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

2.5.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, нэр төрөл, үйлчилгээний чанарыг сайжруулна.

2.5.1.Олон улсын стандартад нийцсэн дүүргийн Нэгдсэн эмнэлгийн барилгыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр барьж, ашиглалтад оруулна.

2.5.2.Хайлааст салбарын Амбулаторийн барилгыг ашиглалтад бүрэн оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

2.5.3.Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр дотоод, гадаадын урт болон богино хугацааны сургалтад хамруулах, туршлага судлуулах ажлыг зохион байгуулж, сайн туршлагыг нутагшуулна.

2.5.4.“Эрүүл шүд” арга хэмжээг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж, шүд, амны хөндийн өвчлөлийг бууруулна.

2.5.5.Ахмад настны эрүүл мэндийг дэмжиж, дүүргийн Нэгдсэн эмнэлэгт “Сэргээн засалт, уламжлалт эмчилгээний төв”, “Ахмадын тасаг”-ийг байгуулна.

2.5.6.Эрүүл мэндийн салбарын барилга байгууламжид шаардлагатай засвар үйлчилгээг хийж, багаж, тоног, төхөөрөмжийг шинэчлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлэн, үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулна.

2.5.7.Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна.

БИЕИЙН ТАМИР, СПОРТ:

2.6.Иргэдийн биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, нийтийн биеийн тамираар хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.

2.6.1.Спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөл боломжийг сайжруулна.

2.6.2.Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ баг, 1-24 дүгээр хороодын Спорт хамтлагийн үйл ажиллагааг өргөжүүлэн, бэлтгэл сургуулилтыг тогтмолжуулж, уралдаан тэмцээнд амжилттай оролцох, чансаа ахиулах нөхцөл боломжоор хангаж ажиллана.

2.6.3.Усан спортын боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, багш дасгалжуулагчдыг чадваржуулан, мэргэжлийн баг бүрэлдэхүүн бэлтгэнэ.

НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ:

2.7.Орон нутгийн хэмжээнд зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэнэ.

2.7.1.Залуучуудын бизнес эрхлэх боломжийг бүрдүүлж, гарааны бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх бодлого баримтлан ажиллана.

2.7.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш оролцох нөхцөл боломжийг нэмэгдүүлж, идэвх санаачилгыг нь дээшлүүлэх чиглэлээр олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохио, замын гарц, тэмдэг тэмдэглэгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй, хүртээмжтэй байхаар төлөвлөн хэрэгжүүлнэ.

2.7.3.“Ахмад настны хөгжлийн төв”-ийг бүсчилсэн хэлбэрээр байгуулж, ахмад настны эрхийг хангах, эрүүл мэндийг хамгаалах, идэвхтэй хөдөлгөөнийг сурталчлах, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, нийгмийн оролцоо идэвхийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр **“Чингэлтэйн ахмадууд-2028”** арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.

2.7.4.Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хөгжил хамгааллыг сайжруулах чиглэлээр гадаад, дотоодын төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

СОЁЛ УРЛАГ:

2.8.Иргэд, олон нийтэд үндэсний өв соёлоо сурталчлан таниулах, өвлүүлэн үлдээх, тэднийг соёл урлагаар дамжуулан соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж, иргэдэд хотын соёлыг төлөвшүүлнэ.

2.8.1.Дүүргийн иргэдийн авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, хотын соёлыг бий болгох, соёл урлагийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжих, соёлын биет болон биет бус өвийг өргөжүүлэн хөгжүүлэх хүрээнд **“Соёлтой иргэн-2028”** арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.

2.8.2.Хороодын “Иргэний танхим”-ыг иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх жишиг танхим болгон тохижуулж, иргэдийг хөгжүүлэх олон талт үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.

2.8.3.Үндэсний түүх, соёл, зан заншил, биет болон биет бус өв, нүүдлийн соёлыг иргэдэд сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлнэ.

2.8.4.Олон үндэстэн угсаатны ардын язгуур урлагийг түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.

2.8.5.“Залуучуудын хөгжлийн төв”, “Гэрлэх ёслолын танхим” бүхий дүүргийн “Соёлын ордон”-г байгуулж, соёл урлагийн салбарыг бүх талаар дэмжин, бие даасан чадамжтай болгоно.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД:

2.9.Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулж, гэр бүлд эрүүл, эерэг харилцаа хандлага төлөвшүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.9.1.Хүүхэд, залуучуудад чиглэсэн хөгжлийн цогц бодлогыг баримталж, **“Хүүхэд залуучуудын хөгжил, хамгаалал-2028”** арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.

2.9.2.“Хүүхэд хөгжлийн цогцолбор”-ыг өргөтгөх ажлын хүрээнд “Хүүхдийн зуслан”-г шинээр байгуулна.

2.9.3.Оюутан, залуусын хөгжлийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүний нөөцийн зохистой бодлогыг баримтална.

2.9.4.Дүүргийн харьяат хүүхэд, гэр бүл, иргэнд тусламж үйлчилгээ, сургалт нөлөөллийн үйл ажиллагаа үзүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, Олон улсын байгууллагын бүртгэл мэдээллийг нэгтгэж, хяналт тавин хамтран ажиллана.

2.9.5.Гэр бүлийн хүчирхийллийн гэрч хохирогчийг хамгаалах “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг олон улсын стандартад нийцүүлэн засварлаж, тохижуулна.

2.9.6.Хүүхэд багачууд, өсвөр үе, залуучуудад эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлж, уламжлалт ёс заншил, өв уламжлалыг сурталчлах, соёлын биет ба биет бус өвийг өвлөн уламжлах чиглэлээр олон талт арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

2.9.7.Өсвөр үе, хүүхэд багачуудыг цахим дээрэлхэлт, цахим гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО:

3.1.Дүүргийн эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд төсвийн оновчтой бодлогыг хэрэгжүүлнэ.

3.1.1.Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын төсвийн зардлыг эдийн засгийн нөөц, улирлын онцлогт нийцүүлэн төлөвлөх замаар төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлаж, төсвийн зардлын үр ашгийг нэмэгдүүлнэ.

3.1.2.Дүүргийн хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санхүүжилтийн шинэ эх үүсвэрийг нэмэгдүүлж, татварын бааз суурийг бэхжүүлнэ.

3.1.3.Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр дүүргийн хэмжээнд хийгдсэн өмч хөрөнгийг эзэнжүүлж, ашиглалт хамгаалалтыг сайжруулна.

3.1.4.Дүүргийн төсвийн тэнцвэрт байдал, эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн нөөц бүрдүүлэн ажиллана.

3.1.5.Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг сайжруулж, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулна.

3.1.6.Төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд тавих хяналтад төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, ил тод, нээлттэй байдлыг хангаж, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлнэ.

3.1.7.Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэмнэлттэй, хариуцлагатай, ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай зохион байгуулж ажиллана.

ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦ:

3.2.Үйлдвэрлэл, инновац, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжинэ.

3.2.1.Гарааны бизнес эрхлэгч, инновац, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлж, бодлогоор дэмжинэ.

3.2.2.Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, зорилтот салбаруудад чиглүүлэх, бараа бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

3.2.3.Бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг бодлогоор дэмжиж, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг төрийн худалдан авах ажиллагаанд оруулах ажлыг шат дараатай зохион байгуулна.

3.2.4.Олон улсын сайн туршлага, экспортод гаргах нөөц бололцоо, санхүүгийн байгууллагуудын эрэлт хэрэгцээг тодорхойлсон мэдээллийн санг бүрдүүлж, төрөлжсөн сургалт, бизнесийн зөвлөх үйлчилгээний ажлыг зохион байгуулна.

3.2.5.Жижиг, дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэгчдийн тодорхой салбарыг кластераар хөгжүүлнэ.

3.2.6.Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд худалдан борлуулах боломжийг бий болгох чиглэлээр **“Чингэлтэйд үйлдвэрлэв-2028”** арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.

ХҮНС ХУДАЛДАА, ҮЙЛДВЭР ҮЙЛЧИЛГЭЭ:

3.3.Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлж, хүнсний бүтээгдэхүүний бүх үе шатанд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах хяналтыг сайжруулж, дүүргийн хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангана.

3.3.1."Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, иргэдийг чанартай, эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангана.

3.3.2.Хүнсний ногоо, жимс жимсгэнэ хадгалах ахуйн зориулалттай загвар зоорийг төр-хувийн хэвшлийн түншлэлийг түшиглэн нийтийн эзэмшлийн газарт байгуулна.

3.3.3.Мал, амьтны гоц халдварт шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт-шинжилгээ хийх, оношлох ажлыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

3.3.4.Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулна.

3.3.5.Мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд махны техникийн зохицуулалтыг нэвтрүүлнэ.

3.3.6.Хүнсний ногооны хадгалалт, борлуулалт, түгээлтийн сүлжээнд ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хангуулж, хэрэглэгчдэд чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ:

3.4.Жуулчдын ая тухтай аялах, зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

3.4.1.Жуулчдад зориулсан соёлын болон тусгай сонирхлын аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, аяллын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоно.

3.4.2.Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал, өрхийн үйлдвэрлэгч нарын төрөлжсөн явуулын үйлчилгээг бий болгож, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана.

3.4.3.Чингэлтэй хайрхан, Зүрх уулыг түшиглэн иргэдийн алхах, ая тухтай амарч зугаалах, аялал жуулчлалын орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

ДӨРӨВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭЛТ:

4.1.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги төлөвлөгөө, “Улаанбаатар хотын цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө”-тэй уялдуулан нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

4.1.1.Айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулах санал санаачилгыг дэмжин урамшуулж, иргэд, хувийн хэвшлийн оролцоотойгоор ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.4.1.2 Хотын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.1.3.Хүүхэд залуучууд, ахмад настнуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх бичил цэцэрлэгт хүрээлэнг хороо бүрд шинээр байгуулна.

4.1.4.Дүүргийн иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, эрүүл, аюулгүй, эрсдэлгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх чиглэлээр **“Тохилог Чингэлтэй-2028”** арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.

4.1.5.Байгаль орчноо хамгаалах, хүрээлэн буй орчинд ээлтэй иргэн бий болгох чиглэлээр хүүхэд, багачууд, өсвөр үе, залуучуудад чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулна.

ХӨРСНИЙ БОХИРДОЛ, ХОГ ХАЯГДАЛ:

4.2.Хөрсний бохирдлыг бууруулах ажлыг цогц хэлбэрээр авч хэрэгжүүлнэ.

4.2.1.Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд нүхэн жорлонгийн тоог багасгах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

4.2.2.Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн бохирдол ихтэй байршлуудад ариутгал халдваргүйтгэлийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.2.3.Хог хаягдал тээвэрлэх, дахин боловсруулах, худалдан авах цогц менежментийг үе шаттай хэрэгжүүлж, өндөр хөгжилтэй орнууд болон орон нутгийн сайн туршлагыг судлан хэрэгжүүлнэ.

4.2.4.“Ухаалаг хогийн сав”-ыг дүүргийн хэмжээнд үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

4.2.5.Хог тээвэрлэлтийн давтамжийг нэмэгдүүлж, гэр хорооллын бүсэд шөнийн тээвэрлэлтийг нэвтрүүлнэ.

4.2.6.Дахин боловсруулсан буюу саарал усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.

4.2.7.Аюултай хог хаягдлын талаарх мэдлэг, боловсрол олгох сургалтыг хүүхэд залуучууд, иргэд, аж ахуйн нэгжүүдэд зохион байгуулж, ангилж устгах ажлыг хэрэгжүүлнэ.

АГААРЫН БОХИРДОЛ:

4.3.Агаар, орчин бохирдуулагч эх үүсвэрийг бууруулж, байгальд ээлтэй хэрэглээг нэмэгдүүлнэ.

4.3.1.Гэр хорооллын айл өрхийн дулааны хангамжийг бусад эх үүсвэрт (төвлөрсөн дулаан, хий, сэргээгдэх эрчим хүч, цахилгаан болон бусад) үе шаттай шилжүүлэн, хатуу түлшний хэрэглээг бууруулж, амины сууцны дулаан алдагдлыг багасгахад иргэд, олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлнэ.

4.3.2.Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд яндангийн тоог бууруулж, хүлэмжийн хийн ялгаралтыг багасгах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, агаарын бохирдлыг бууруулна.

ТАВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

ЗАСАГЛАЛЫН ШИНЭЧЛЭЛТ:

5.1.Хүний эрхийг дээдэлсэн, ёс зүйн хэм хэмжээг баримталж, авлигаас ангид, ил тод, үр нөлөөтэй, цахимжсан хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалын бодлогыг хэрэгжүүлнэ.

5.1.1.Төрийн албаны үйл ажиллагаа, бүтээмж, чанарын удирдлагын нэгдсэн систем, хяналт хариуцлагын тогтолцоог шинэ шатанд гаргаж, төрийн албан хаагчийн ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах зорилгоор **"Хүний нөөц, нийгмийн баталгаа-2028"** арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.

5.1.2.Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдын орон сууцыг барьж, ашиглалтад оруулна.

5.1.3.Ажлын байрны дүн шинжилгээнд үндэслэн тухайн нэгжийн чиг үүрэг, ажилтны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, ажлын давхардал, хийдлийг арилгана.

5.1.4.Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, дүүргийн хөгжлийн талаарх үр ашигтай санал, санаачилгыг дэмжиж ажиллана.

5.1.5.Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, төр-иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

5.1.6.Засаг захиргааны анхан шатны нэгжийн үйл ажиллагаанд засаглалын шинэ хэлбэрийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэнэ.

5.1.7.Хороодын "Нэг цэгийн үйлчилгээ"-ний үйл ажиллагааг тогтмолжуулан, иргэдэд төрийн үйлчилгээг "Хурдан цэг"-ээр дамжуулан түргэн, шуурхай, чирэгдэлгүй үзүүлэхэд анхаарч, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг тогтмол анхаарч ажиллана.

5.1.8.Бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгох хөтөлбөрийг боловсруулж, тэгш хүртээмжтэй хэрэгжүүлнэ.

5.1.9 Дүүргээс хэрэгжүүлж буй бүхий л төсөл хөтөлбөр, үйл ажиллагаа, бодлогын баримт бичиг, шийдвэрүүд хүний эрхэд суурилсан байна.

5.1.10.Төрийн албан хаагчдын ёс зүй, шударга байдлыг төлөвшүүлэх зорилгоор авлигын эрсдэл, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд төрийн албан хаагч болон удирдах албан тушаалтнуудад ёс зүйн зөрчил, авлигын эсрэг сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

ГАДААД ХАРИЛЦАА:

5.2.Дэлхийн улс орнуудын нийслэл, дүүрэг болон хотуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж ажиллана.

5.2.1.Гадаадын улс орон, хот дүүргүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, соёл, спорт, боловсрол, эрүүл мэнд, гамшгийн эрсдэлийг бууруулах, ажиллах хүчний солилцоо зэрэг нийгмийн бүхий л салбарт хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

5.2.2.Хамтын ажиллагаатай улс, хотуудад Монголын үндэсний өв уламжлал, зан заншил, соёлыг сурталчлах зорилгоор урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулна.

5.2.3.Хамтын ажиллагаатай гадаадын хот, дүүргийн хооронд "Сурагч солилцоо", ижил түвшний төрийн байгууллагын хооронд "Албан хаагчдын солилцоо"-ны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

ЦАХИМ ШИЛЖИЛТ:

5.3.Цахим шилжилтийн хүрээнд "Цахим Чингэлтэй-2028" арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.

5.3.1.Дүүргийн харьяа байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, аюулгүй байдлыг ханган хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулна.

5.3.2.Дүүргийн харьяа байгууллагуудын Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулж, салбарын албан хаагчдын мэргэжил, арга зүйг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

5.3.3.Дүүрэг дэх Төрийн архив болон хөмрөг үүсгэгч байгууллагуудын архивд хадгалагдаж буй цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ.

5.3.4.Дүүргийн хэмжээнд кибер аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ.

5.3.5.Салбар архивын үйл ажиллагааг өргөжүүлж, иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх архивын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

БАТЛАН ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

5.4.Батлан хамгаалах бодлого үйл ажиллагааг иргэдийн оролцоотой сурталчлан, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, эх орноо батлан хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг нэмэгдүүлнэ.

5.4.1.Орон нутгийн хамгаалалтын бэлтгэл, дайчилгааны бэлэн байдлыг нэмэгдүүлж, төрийн байгууллагууд болон аж ахуйн нэгжийн гүйцэтгэх үүрэг, ажлын уялдаа холбоог хангаж ажиллана.

5.4.2.Иргэдэд эх оронч үзэл төлөвшүүлэх, Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудад сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлнэ.

5.4.3.Өсвөр үе, хүүхэд залуучуудын эх орноо батлан хамгаалах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг үе шаттайгаар зохион байгуулна.

5.4.4.Цэрэг татлагын хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор өсвөр үе, залуучуудад эх орноо батлан хамгаалах хүсэл эрмэлзлийг төлөвшүүлж, “Эх оронч цэрэг-2028” арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.

ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

5.5.Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлж, аюулт үзэгдэл, ослоос аврах ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

5.5.1.Шинэ гал унтраах ангийн барилгын ажлыг дуусган ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

5.5.2.Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулж, инновацыг ашиглах замаар гамшгийн бэлэн байдлыг дээшлүүлнэ.

5.5.3.Гал унтраах ангид ашиглагдах үндсэн болон шуурхай албаны техник хэрэгслийг сайжруулах замаар гал унтраах үйл ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулж, иргэдийн амь нас, эд хөрөнгийг авран хамгаална.

5.5.4.Хороодын гамшгийн үеийн бэлэн байдал, урьдчилан сэргийлэх чадавх нэмэгдүүлж, гамшгаас хамгаалах иргэдийн сайн дурын бүлгийг сургаж бэлтгэнэ.

5.5.5.Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, газ болон тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдлын стандартыг мөрдүүлж хяналтыг сайжруулна.

5.6.Иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.6.1.Хууль, тогтоомжийг иргэдэд сурталчлах, оролцоог дэмжих олон талт арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

5.6.2.Ил тод байдлыг сайжруулан хүнд суртал, чирэгдлийн бууруулж, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлнэ.

5.6.3.Дүүргийн “Камерын хяналтын төв”-ийн программ хангамжийг хөгжүүлж, яаралтай түргэн тусламж, гал түймэр, гамшиг осол, цагдаагийн байгууллагын яаралтай дуудлагыг шуурхай хүлээн авч, нөхцөл байдлыг алсын зайнаас хянах тогтолцоог бий болгоно.

5.6.4.Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна.

5.6.5.Насанд хүрээгүй хүүхдэд электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглох, сургуулийн орчинд утаат болон электрон тамхины хэрэглээнд хатуу хяналт тавих, хорт зуршлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

5.6.6.Архи согтууруулах ундаа, хар тамхи, мансууруулах бодис, утаат болон электрон тамхины хор нөлөөг ойлгуулах, хэрэглэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өсвөр насны хүүхэд, залуучууд, олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.14 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.7, 60.3, 60.5 дахь хэсэг Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192, А/243 дугаар хамтарсан тушаал, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны А/82 дугаар тушаалыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит II хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад дараах өөрчлөлтийг оруулсугай.

1.1. 2.2. “8 нэрийн хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 50 мк² хүртэл/ 100,000 төгрөг” гэснийг “8 нэрийн хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 50 мк² хүртэл/ 70,000 төгрөг” гэж;

1.2. 2.3. “8 нэрийн хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 51-200 мк² хүртэл болон Супермаркет/ 130,000 төгрөг” гэснийг “8 нэрийн хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 51-200 мк² хүртэл болон Супермаркет/ 90,000 төгрөг” гэж;

1.3. 2.6. “Хүнсний зах 150,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэснийг “Хүнсний зах 200,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэж;

1.4. 2.7. “Барааны зах 150,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэснийг “Барааны зах 200,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэж;

1.5. 2.8. “Их дэлгүүр 2,000,000 төгрөг” гэснийг “Их дэлгүүр 200,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэж;

2.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 6.3.“Банк, Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр” гэсний “Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр” гэснийг хассугай.

3.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад 6.3.1.“Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр 70,000 төгрөг” гэж нэмсүгэй.

4.Энэ тогтоолын нэмэлт, өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, сурталчлан таниулж, дагаж мөрдүүлэхийг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д үүрэг болгосугай.

5.“Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдэж, хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

**Төрийн цол, одон медалиар
шагнуулахаар уламжлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг “Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”-ыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит II хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулах болзол хангаж, байгууллага, хамт олноос тодорхойлж ирүүлсэн дараах иргэдийн шагнуулах саналыг дэмжиж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсугай. Үүнд:

“МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР ЦОЛ”-оор:

- | | | | |
|----|--------|-----------|---|
| 1. | Раздак | Сандалхан | Чингэлтэй дүүрэг дэх Авто тээврийн нэгдсэн холбооны ахмад ажилтан |
|----|--------|-----------|---|

“МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЬЯАТ АЖИЛТАН ЦОЛ”-оор:

- | | | | |
|----|-------|----------|---|
| 1. | Гэнэн | Бүдсүрэн | Чингэлтэй дүүргийн 10 дугаар хорооны ахмад настан |
|----|-------|----------|---|

“МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ”-оор

- | | | | |
|----|--------|-----------|---|
| 1. | Оохной | Батсайхан | Чингэлтэй дүүрэг дэх Олон улс судлалын хүрээлэнгийн ажилтан |
|----|--------|-----------|---|

“МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЭМЧ ЦОЛ”-оор:

- | | | | |
|----|------|-------|---|
| 1. | Санж | Пүрэв | Чингэлтэй дүүрэг дэх Монголын үндэсний мал эмнэлгийн холбооны ахмад ажилтан |
|----|------|-------|---|

“МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ТЭЭВЭРЧИН ЦОЛ”-оор:

- | | | | |
|----|------------|-----------|---|
| 1. | Санжжав | Ганболд | Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн ахмадын хорооны ахмад ажилтан |
| 2. | Галсандорж | Лхамсүрэн | Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн ахмадын хорооны ахмад ажилтан |

150100121

- | | | | |
|----|-----------|------------|---|
| 3. | Нямаа | Мягмар | Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн ахмадын хорооны ахмад ажилтан |
| 4. | Лувсан | Түдэв | Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн ахмадын хорооны ахмад ажилтан |
| 5. | Даржаа | Совдоо | Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн ахмадын хорооны ахмад ажилтан |
| 6. | Төгс | Пүрэвдорж | Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн ахмадын хорооны ахмад ажилтан |
| 7. | Лэгцэгпил | Чагнаадорж | Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн ахмадын хорооны ахмад ажилтан |

“МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ НИСГЭГЧ ЦОЛ”-оор:

- | | | | |
|----|--------|--------|--|
| 1. | Рэнцэн | Гонгор | Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны ахмад настан |
|----|--------|--------|--|

“СҮХБААТАРЫН ОДОН”-оор:

- | | | | |
|----|-----------|-------------|---|
| 1. | Лхаасүрэн | Ганболд | Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн ахмадын хорооны ахмад ажилтан |
| 2. | Дансран | Галбадрах | Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн ахмадын хорооны ахмад ажилтан |
| 3. | Намсрай | Нямдаваа | Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн ахмадын хорооны ахмад ажилтан |
| 4. | Дамба | Туяа | Чингэлтэй дүүрэг дэх “АйСВН” ХХК-ийн захирал |
| 5. | Жадамба | Түмэнжаргал | Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн ахмадын хорооны ахмад ажилтан |

“ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН”-оор:

- | | | | |
|----|-------------|------------|--|
| 1. | Бат-Очир | Алтанцэцэг | Чингэлтэй дүүрэг дэх Шинэ иргэншил политехник коллежийн багш |
| 2. | Балжинням | Баатармөнх | Чингэлтэй дүүрэг дэх Авто мастер төв ХХК-ийн захирал |
| 3. | Бямба | Дагина | Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн нэгдсэн холбооны ахмад ажилтан |
| 4. | Дэмчигсүрэн | Нямсүрэн | Чингэлтэй дүүргийн 20 дугаар хорооны иргэн |
| 5. | Пунцаг | Ориг | Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн нэгдсэн холбооны ахмад ажилтан |

6.	Буд	Сэлэнгэ	Чингэлтэй дүүргийн 8 дугаар хорооны ахмад настан
7.	Лхамсүрэн	Сэрээтэр	Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн нэгдсэн холбооны ахмад ажилтан
8.	Гэндэндорж	Тунгалаг	Чингэлтэй дүүрэг дэх "Монголын барилгын инженер-геологичдын холбоо" Төрийн бус байгууллагын ажилтан
9.	Сейтхазы	Хайыпхан	Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн нэгдсэн холбооны ахмад ажилтан
10.	Даржаа	Цогтбаатар	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны ахмад настан
11.	Пэлжээ	Цэрэндашмаа	Чингэлтэй дүүргийн 8 дугаар хорооны ахмад настан
12.	Гүнжээ	Энхжаргал	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны ахмад настан
13.	Рончир	Эрдэнэчимэд	Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн нэгдсэн холбооны ахмад ажилтан

“АЛТАН ГАДАС ОДОН”-оор:

1.	Совд	Адилбиш	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны иргэн
2.	Шагдар	Бөөрөнхий	Чингэлтэй дүүрэг дэх Улсын их дэлгүүрийн ахмадын холбоо ГҮТББ-ын ахмад ажилтан
3.	Гомбожав	Лхагваа	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны ахмад настан
4.	Шагж	Лувсан	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны иргэн
5.	Цагаан	Нина	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны иргэн
6.	Оотон	Халтар	Чингэлтэй дүүрэг дэх Энх-Өрнөлт ХХК-ийн захирал
7.	Бадрах	Түвдэндорж	Чингэлтэй дүүрэг дэх 10 дугаар хорооны иргэн
8.	Давхар	Удвал	Чингэлтэй дүүрэг дэх "Улсын их дэлгүүрийн ахмадын холбоо" ГҮТББ-ын ахмад ажилтан
9.	Сономцэрэн	Сосорбурам	Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны ахмад настан

10. Жужаа	Сүрэнжав	Чингэлтэй дүүрэг дэх Нийслэлийн хөдөлмөр халамж үйлчилгээний газрын ахмад ажилтан
11. Сайнжаргал	Сэр-Од	Чингэлтэй дүүргийн 21 дүгээр хорооны иргэн
12. Соном	Цэндсүрэн	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн
13. Даржаа	Цэрэндорж	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны иргэн
14. Аюуш	Цэнддоо	Чингэлтэй дүүрэг дэх "Улсын их дэлгүүрийн ахмадын холбоо" ГҮТББ-ын ахмад ажилтан
15. Батсүх	Чанцалмаа	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны иргэн
16. Довдон	Шүрэнцэцэг	Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн нэгдсэн холбооны хяналтын зөвлөлийн гишүүн
17. Базаррагчаа	Янжинсүрэн	Чингэлтэй дүүргийн 8 дугаар хорооны ахмад настан

“ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОН”-оор:

1. Батчулуун	Цэдэн	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Тоо бүртгэлийн офицер
--------------	-------	--

“ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-иар:

1. Жамсран	Аюуш	Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн нэгдсэн холбооны менежер
2. Жанцансамбуу	Алтанболд	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны иргэн
3. Өлзий	Буянжаргал	Чингэлтэй дүүрэг дэх “Чин-Хүслэн” ӨЭМТ-ийн сувилагч
4. Баясгалан	Баярсайхан	Чингэлтэй дүүрэг дэх Авто тээвэрчдийн нэгдсэн холбооны ахмад ажилтан
5. Дорж	Гандолгор	Чингэлтэй дүүргийн 21 дүгээр хорооны иргэн
6. Норов	Гонгор	Чингэлтэй дүүргийн 21 дүгээр хорооны иргэн
7. Цэрэнбатаа	Даваасүрэн	Чингэлтэй дүүргийн Дотоод аудитын албаны аудитор

8.	Амгалан	Долгормаа	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны иргэн
9.	Хаянхярваа	Долгорсүрэн	Нийслэлийн ерөнхий боловсролын Дизайн технологийн багш
10.	Базарсад	Ичинхорлоо	Нийслэлийн ерөнхий боловсролын 139 дүгээр сургуулийн хөгжмийн багш
11.	Оюун	Мөнхтунгалаг	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны хэсгийн ахлагч
12.	Дуламрагчаа	Мөнхжаргал	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны хэсгийн ахлагч
13.	Цогтбаатар	Мөнхбаяр	Чингэлтэй дүүрэг дэх "АйСВН" ХХК-ийн жолооч
14.	Аварзэд	Наранбаатар	Чингэлтэй дүүрэг дэх "Хайпэй" ХХК-ийн мэдээлэл технологи хариуцсан захирал
15.	Гончиг	Норов	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны иргэн
16.	Дондов	Оюунчимэг	Чингэлтэй дүүрэг дэх 247 дугаар цэцэрлэгийн багш
17.	Баатар	Оюунтуяа	Чингэлтэй дүүрэг дэх Хадгаламж банкны Нягтлан бодогч
18.	Должин	Оюун-Эрдэнэ	Чингэлтэй дүүрэг дэх "Монкон Консорциум" ХХК-ийн ажилтан
19.	Ганхуяг	Саруул-Од	Чингэлтэй дүүрэг дэх "Хайпэй" ХХК-ийн захирал
20.	Энх-Амгалан	Сайханжаргал	Чингэлтэй дүүрэг дэх "Хайпэй" ХХК-ийн бүртгэл хариуцсан захирал
21.	Дашцэрэн	Сэржханд	Чингэлтэй дүүрэг дэх Мастер фүүдс ХХК-ийн ажилтан
22.	Раш	Сосорбурам	Чингэлтэй дүүргийн 103 дугаар цэцэрлэгийн багш
23.	Цэдэв	Тунгалаг	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны иргэн
24.	Батмөнх	Ууганцэцэг	Нийслэлийн ерөнхий боловсролын 139 дүгээр сургуулийн сургалтын менежер
25.	Хуяг	Цол-Өрнөх	Чингэлтэй дүүрэг дэх "АйСВН" ХХК-ийн жолооч

26. Шарав	Чулуунбаатар	Чингэлтэй дүүрэг дэх "Батхулд трейд" ХХК-ийн ахмад ажилтан
27. Зундуй	Цэрэннадмид	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны ахмад настан
28. Дамбажанцан	Цэрэнлхам	Нийслэлийн ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн бага ангийн багш
29. Чогсүрэн	Цэцэгмаа	Нийслэлийн ерөнхий боловсролын 139 дүгээр сургуулийн бага ангийн багш
30. Чадраабал	Энхтөгс	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны иргэн
31. Түгж	Эрдэнэчулуун	Чингэлтэй дүүргийн 21 дүгээр хорооны ахмад настан
32. Чалхаасүрэн	Энхгэрэл	Чингэлтэй дүүрэг дэх Монгол Бичээч Зууч ХХК-ийн гүйцэтгэх захирал
33. Цэрэн	Энхболд	Чингэлтэй дүүрэг дэх "АйСВН" ХХК-ийн жолооч
34. Дорж	Энх-Амар	Нийслэлийн ерөнхий боловсролын 139 дүгээр сургуулийн бага ангийн багш

2.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР